

**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТААР ИЛЭРСЭН АКТ, АЛБАН ШААРДАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

№	Аудитын илрүүлэлт	Дүгнэлт/зөвлөмж	Мөнгөн дүн	Аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелсэн дүн	Явцын мэдээлэл тайлагнасан хувь
1	Албан томилолтоор ажилласан 2 ажилтаны цалин хөлсийг тооцоолохдоо, томилолтоор ажилласан хугацаанд 0.2 сая төгрөгийн хоол унааны нэмэгдлийг давхардуулан олгосон байна.	Хоол унааны нөхөн олговрыг давхардуулан олгосныг буруутай ажилтнаар төлүүлэх	195,000.00	195'000 Нэг зуун ерэн таван мянган/ төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэх	Үндэсний аудитын газрын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 132/A0150061 САГА-2024/54/НА-СТА-ТӨА тоот Төлбөр барагдуулах тухай актын дагуу 195'000 төгрөгийг Аудитын шалгалтын орлогын дансанд төвлөрүүлэв.	195,000.00	100%
2	Элгдлээрээ анхны өртгөө нөхсөн 75 төрлийн 11.0 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	Эрх бүхий байгууллагад уламжлан үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгэх	-	2023 оны актлах хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу ТӨБЗГ-т хандан шийдвэрлүүлэх, цаашид ашиглах боломжтой элгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох	2023 оны актлах хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн актлах, дахин үнэлэх саналыг компанийн ТУЗ-ийн хуралд оруулан шийдвэрлүүлсэн. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 26 тоот тогтоолын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулах газарт 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/437 тоот албан бичгээр хандан актлах болон дахин үнэлэх хөрөнгүүдийг шийдвэрлүүлэхээр хүсэлт өгсөн. ТӨБЗГ-аас 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А-1/1135 тоот хариу албан бичигт Монголын хөрөнгийн бирж нь Хувьцаат компани болсон тул компанийн дүрмийн дагуу шийдвэр гарган ажиллах ба ингэхдээ 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг дагаж мөрдөн ажиллахыг үүрэг болгов. Компанийн өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж, ТӨБЗГ-аас ирүүлсэн бичгийг авч хэлэлцээд, компанийн дүрмийн дагуу шийдвэр гаргах нь "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг дагаж мөрдөн ажиллахад зөрилдөж байгаа тул хөрөнгийг актлах, устгах, дахин үнэлэхийг ТӨБЗГ-аас зөвшөөрөл авахаар дахин албан тоот хүргүүлэхээр шийдвэрлэж, албан тоотыг хүргүүлэн ажиллаж байна. Ирүүлсэн зөвшөөрөл, ниглэлийн дагуу ажиллана. Холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв.	-	100%
3	Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум дахь шалгагдагч байгууллагын эзэмших эрх бүхий газар тариалангийн зориулалттай 304 га газрыг 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр тус аймгийн "Бүрэн Эрдэнэ монос" ХХК-д худалдаж, тус компани нь газрын үнэ 19.8 сая төгрөгийг 3 жилийн хугацаанд төлж барагдуулахаар худалдах худалдан авах гэрээ байгуулсан байна. Уг гэрээ нь хууль тогтоомжид нийцээгүй тул худалдан авах талын газрын үнэнд төлсөн 19.8 сая төгрөгийг өглөгөөр бүртгэж, газрыг бусад эргэлтийн хөрөнгөөр одоог хүртэл бүртгэж, тайлант онд газрын төлбөрт 0.3 сая төгрөг төлж үргүй зардал гаргасан байна.	Компанийн эзэмшил дэхь тариалангийн газрыг "Бүрэн Эрдэнэ монос" ХХК-д олон жил үнэ төлбөргүй ашиглуулсан, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	20,045,000.00	"Бүрэн Эрдэнэ монос" ХХК-тай холбогдох газар эзэмших эрх болон, ашиглалтын талаархи асуудлаар ТУЗ-ийн хурлаар хурлаар хэлэлцүүлэн, шийдвэр гаргуулах, шийдвэрийн дагуу хийгдэх ажлыг тухай бүр зохион байгуулах, хэрэгжилтийг тухай бүр Гүйцэтгэх удирдлагад, үр дүнг УАГ-т 2024 оны 09 сарын 30-н дотор тайлагнан ажиллах,	"Бүрэн эрдэнэ монос" ХХК-тай холбоотой танилцуулгыг бэлтгэн ТУЗ-д танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулан 2024 оны 04 сарын 18-ны өдөр 01/307 тоот албан бичгээр "Бүрэн эрдэнэ монос" ХХК-д газар чөлөөлөх тухай мэдэгдлийг хүргүүлсэн. 2024 оны 04 сарын 29-ний өдөр Сэлэнгэ аймаг дахь Баруунбүрэн сумын 244 га газартай танилцсан. "Бүрэн эрдэнэ монос" ХХК-нас газар чөлөөлүүлэх нэхэмжлэлийг 2024 оны 05 сарын 21-ний өдөр Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхэд өгсөн. Уг маргааны хувьд иргэний хэрэг үүссэн бөгөөд хариуцагч нэхэмжлэлийн хувийг гардан авч хариу тайлбараа ирүүлсэн байдалтай ажиллагаа явагдсан. Дахин худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох, барилгыг үнэлэх ажиллагаа явагдаж байна. 2024 оны 09 сарын 09-ний өдөр шүүх хурал зарлагдсан. Холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв.	20,045,000.00	100%
4	Авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг тулган шалгахад 19 харилцагчийн 22.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	22,360,990.43	Өмнөх оны авлагын үлдэгдлийг 2024 оны 8 сарын 31 дотор тулган баталгаажуулж дуусгах, 2024 оны жилийн эцсийн авлагын үлдэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 20-ний дотор тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулалт хийх;	Авлагын тооцоог 17 харилцагчийн 21.7 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулав. Тооцоо нийлсэн актуудыг хавсралтаар хүргүүлэв.	22,360,990.43	100.00%
5	Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тулган шалгахад 20 харилцагчийн 3.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	3,406,369.73	Өмнөх оны өглөгийн үлдэгдлийг 2024 оны 8 сарын 31 дотор тулган баталгаажуулж дуусгах, 2024 оны жилийн эцсийн өглөгийн үлдэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 20-ний дотор тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулалт хийх;	20 харилцагчийн 3.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулав. Тооцоо нийлсэн актуудыг хавсралтаар хүргүүлэв.	3,406,369.73	100%

6	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Тус компанийн санхүүгийн ажилтнууд нь шинээр нэмэгдсэн үйл ажиллагааны чиглэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого арга зүйг стандартад нийцүүлэн боловсруулж, НББББ-т өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр тусгаж, мөрдөн ажиллах" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, боллогын өөрчлөлтийг НББББ-т тусгаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	-	Компанийн НББББ-ийн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж дуусган, Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэх, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан, мөрдөж ажиллах;	Компанийн НББББ-ийн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж дуусган, шинэчилсэн НББББ-ийг Гүйцэтгэх захирлын 2024 оны 06 сарын 27-ны өдрийн А/278 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Тушаалыг хавсралтаар хүргүүлэв.	-	100%
7	Нийт 37 байгууллагын 232.3 сая төгрөгийн найдваргүй авлагын үлдэгдлийг, санхүүгийн програмын тохиргооноос шалтгаалан авлагыг сөрөг утгатайгаар бүртгэж авлагыг бууруулж, бүртгэсэн байна.	Санхүүгийн програмд тохируулга хийн үнэн зөв тайлагнаж байх	232,346,532.22	Санхүүгийн програмд тохируулга хийх	Компани 2024 онд санхүүгийн шинэ программ нэвтрүүлсэн бөгөөд тухайн программ найдваргүй авлагын хасагдуулга дансыг сөрөг утгатайгаар бүртгэдэг. Бүх санхүүгийн программууд нь найдваргүй авлагын хасагдуулга дансыг дебит талд сөрөг утгатайгаар бүртгэдэг байна. Ингэснээр дансны авлагыг санхүүгийн тайланд цэвэр дүнгээр тайлагнадаг.	232,346,532.22	100%
8	Дотоод хяналтын алба нь тайлант онд гүйцэтгэх ажлын батлагдсан төлөвлөгөөг, хяналт шалгалтыг 1 удаа хийж 3 зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилтийг тооцоогүй байна.	Дотоод хяналтын албаны сар, улирал, жилийн төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн тайлангийн аудит болон Сангийн яамны СХЭУГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Дотоод хяналтын албаны сар, улирал, жилийн төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн тайлангийн аудит болон Сангийн яамны СХЭУГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Дотоод хяналтын албаны жил, улирлын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023, 2024 оны төлөвлөгөөг хавсаргав. Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сар 09-ний өдөр баталсан СХЭУГ/01 тоот удирдамжийн дагуу компанийн 2022-2023 онуудын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг Сангийн яамны СХЭУГ-т 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хүргүүлснийг хавсаргав.	-	100%
9	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлыг Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолоор батлаагүй, зорилгот түвшинд удирдлагын зардалд 151.4 сая төгрөгийг баталснаас гүйцэтгэээр 152.8 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төлөвлөгөөг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	Удирдлагын зардлыг хэтрүүлсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	1,422,460.00	Компанийн Хувь нийлүүлэгчдийн хурал, ТУЗ-өөс баталсан Удирдлагын зардлыг төлөвлөгөөний дагуу зарцуулалтыг хийх; тухайн жилийн зарцуулалтыг улирал тутам Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-д тайлагнан ажиллах;	2024 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшнийг баталсан бөгөөд энэхүү зорилгот түвшний хүрээнд удирдлагын зардал батлагдсан. Батлагдсан зардлын төлөвлөгөөний дагуу зарцуулалтыг гүйцэтгэн, хяналтийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	1,422,460.00	100%
10	Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 7 иргэн, байгууллагын дүн 0.8 сая төгрөгөөр илүү, 27 иргэн байгууллагын дүн 5.6 сая төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлдэггүй, төлбөрийн цахим системд бүртгэгдсэн н-баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	6,363,035.99	Дутуу төлбөрийн баримтуудыг төлбөрийн цахим системд нөхөн бүрдүүлэх, илүү бүртгэгдсэн төлбөрийн баримтуудыг цахим системээс устгуулах, тайлант энэхүү зөрчлийг давтан гаргахгүй байх;	2024 онд ибармтаар нотлогдох бүх ажил гүйлгээнд ибармтын бүрдлийг ханган ажиллаж байна.	6,363,035.99	100%
11	Татан төвлөрүүлсэн 11,915.8 сая төгрөгийн хөрөнгөөс тайланд онд 1,487.1 сая төгрөгийг зарцуулснаас МП системийн ашиглалтын зардалд жил бүр төлдөг урсгал зардалд 455.1 сая төгрөгийг зарцуулсан байна.	Татан төвлөрүүлсэн хөрөнгийг биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлж, үр ашгийг нэмэгдүүлсэн байхар төлөвлөж зарцуулах	455,075,660.00	Татан төвлөрүүлсэн хөрөнгийг биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлж, үр ашгийг нэмэгдүүлсэн байхар төлөвлөх	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 28 дугаар тоот тогтоолоор татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 2024 онд санхүүжүүлэх зарцуулалтын төлөвлөгөөний тодотголыг баталсан. Ингэхдээ татан төвлөрүүлсэн хөрөнгөөс МП системийн жилийн үйлчилгээний зардлыг санхүүжүүлн гэсэн байсныг хасч татан төвлөрүүлсэн хөрөнгийн 2024 оны төлөвлөгөөг тодотгосон. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс биржийн арилжааны системийн сайжруулалт, мэдээлэл технологийн аюулгүй байдал, үйл ажиллагааны цахимжуулалт, хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжинд оруулах хөрөнгө оруулалтыг төлөвлөн, төлөвлөгөөний дагуу зарцуулж байна. ТУЗ-ийн тогтоолыг хавсаргав.	455,075,660.00	100%
12	Төлөөлөн удирдах зөвлөлийн "Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн албан ёсны оноосон нэрийг "Монголын хөрөнгийн бирж УУББ"ХК болгон өөрчлөхөөр тогтоосон боловч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулаагүй байна.	ТУЗ-ийн тогтоолыг хэрэгжүүлж гэрчилгээ, дүрмэнд тусгах эсэх асуудлыг ХЭХ-аар шийдвэрлэх	-	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх	2024 оны 04 дүгээр сарын 26 өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлаар оролцуулан шийдвэрлүүлэв. Тус хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн "Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Компанийн албан ёсны оноосон нэрийг "Монголын хөрөнгийн бирж УУББ"ХК болгон өөрчлөх шийдвэрийг хүчингүй болгов. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26 өдрийн 03 тоот шийдвэрийг хавсаргав.	-	100%
13	Шаллагдагч байгууллага нь 1.3 сая төгрөгийн 383.47 литр шатахууныг авто машин ашиглалтын гэрээгүй, замын хуудсаар тооцоог бодоогүй олгосон байна.	Автомашины ашиглалтын гэрээгүй, шатахууны зардал гаргасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	1,287,060.99	2023 оны шатахууны зардлыг замын хуудсаар тооцоог нөхөн бодох-2024 оны 6 сарын 30-ны дотор, 2024 онд холбогдох гэрээ, замын хуудасны тооцоогүй шатахууны зардлыг гаргахгүй байх;	1.3 сая төгрөгийн 383.47 литр шатахууныг замын хуудсаар тооцоог бодож олгосныг шатахууны тооцоо, замын хуудсаар баталгаажуулав. Замын хуудас, шатахууны тооцоог хавсаргав.	1,287,060.99	100%

14	Албан томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад давхардсан тоогоор 6 хүнд 1.6 сая төгрөгийн албан томилолтын зардлыг илүү олгосон байна.	Томилолтын илүү тооцож олгосныг буруутай ажилтнаар төлүүлэх	1,639,930.07	1'636'930 /Нэг сая зургаан зуун гучин зургаан мянга есөн зуун гучин/ төгрөгийн төлбөрийг актыг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэх	Үндэсний аудитын газрын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 134/А0150061 СНАГ-2024/54/НА-СТА-ТӨА тоот Төлбөр барагдуулах тухай актын дагуу 1'636'930 төгрөгийг Аудитын шалгалтын орлогын дансанд төвлөрүүлэв.	1,639,930.07	100%
15	ТУЗ-ын 2023 оны 27 дугаар тогтоолоор 13 нэр төрлийн 9,783.7 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг баталснаас гишүүн байгууллагын хураамжийн орлого, төмрийн арилжааны шимтгэл, бусад орлого, банкны хүүгийн орлого, нүүрсний арилжааны шимтгэлийн орлого нийт 5 төрлийн орлогын төлөвлөгөө 32.7-4,224.2 сая төгрөгөөр давж, 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 8.3-1,179.3 сая төгрөгөөр тасарсан байна.	Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр ханган биелүүлэх, зорилгот түвшний орлого зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж байх.	1,855,794,030.00	Орлого зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх	ТУЗ-ийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 28 дугаар тогтоолоор 14 нэр төрлийн 37,076 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг батлаж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.	1,855,794,030.00	100%
16	Шалгагдагч байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1 суудлын автомашины улсын дугаар цагаан өнгөтэй байна.	Авто тээврийн хэрэгслийг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгох.	-	Компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй суудлын авто тээврийн хэрэгслийг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар хэрэглэх тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандаж чиглэл хүсэх	Аудитын зөвлөмжөөр ирүүлсэн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1 суудлын тээврийн хэрэгслийг компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс их хэмжээний засвар үйлчилгээ шаардлагатай, засвар үйлчилгээ хийгдсэн ч эдийн засгийн хувьд үр ашиггүй гэж үзэн актлах санал гаргасан. Төрийн өмчийн бодлого зохицуулах газарт 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/438 тоот албан бичгээр хандан актлан данснаас хасах, актлан дуудлага худалдаагаар худалдах, данснаас хасах хүсэлт өгсөн. ТӨБЗГ-аас 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А-1/1135 тоот хариу албан бичигт Монголын хөрөнгийн бирж нь Хувьцаат компани болсон тул компанийн дүрмийн дагуу шийдвэр гарган ажиллах ба ингэхдээ 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг дагаж мөрдөн ажиллахыг үүрэг болгов. Компанийн өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж, ТӨБЗГ-аас ирүүлсэн бичгийг авч хэлэлцээд, компанийн дүрмийн дагуу шийдвэр гаргах нь "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг дагаж мөрдөн ажиллахад зөрчилдөж байгаа тул хөрөнгийг актлахыг ТӨБЗГ-аас зөвшөөрөл авахаар дахин албан хүсэлт илгээхээр шийдвэрлэж, хүсэлтийг илгээв. Мөн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтад байгууллага нь төрийн болон албаны нууцыг хамгаалах талаар "... шаардлагатай хөрөнгийг төсөвтөө тусгаж санхүүжүүлэх саналаа эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх" бүрэн эрхтэй гэж заасан ба "Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө"-ний хавсралт "Нууц баримт бичиг бусад тээгчийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн судалгаа"-ны дагуу тээврийн хэрэгсэл худалдан авахаар компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд тусган батлуулсан. Иймд тус тээврийн хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулж, түүнд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар хэрэглэх тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандаж чиглэл хүсэв.	-	100%
17	Шалгагдагч байгууллага нь хот дотор суудлын авто машинд 1.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	Хот дотор суудлын авто машинд шатахуун зарцуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх.	1,213,419.07	Зөрчлийг давтан гаргахгүй байх	2023 оны замын хуудас, шатахууны тооцоог баталгаажуулав. 2024 онд шатахууны зардал гараагүй болно.	1,213,419.07	100%